

Түүх 4 : Соломон

Библийн эшлэл
[1Хаад 3:9-10]

Тиймээс Таны ард түмнийг засаглахын тулд ухааран ойлгох зүрх,
сайн мууг ялгаж салгах ухааныг Өөрийн зарцдаа өгөөч.
Учир нь таны энэ агуу их ард түмнийг хэн засаглаж чадах билээ? гэв.
Соломон энэ зүйлийг гүйсэн нь ЭЗЭНий мэлмийд таашаагдав.

Израилийн хаан Соломон, эцэг Давид хаан шигээ Бурханд хайртай нэгэн байлаа.

Тэр үед Израильд, Бурханд зориулан босгосон ариун сүм баригдаагүй байлаа.

Тиймээс ард түмэн өндөрлөг газар дээр гарч Бурханд мөргөл өргөдөг байлаа.

Соломон хаан Гибеонд мөргөл өргөхөөр иржээ.

Тэнд маш том тахилын ширээ байдаг байв. Соломон хаан тэр тахилын ширээн дээр мянган тахил өргөхөд, Бурхан өргөлийг баяртайгаар хүлээн авсан юм.

Нэгэн өдөр Соломон хааны зүүдэнд Бурхан үзэгджээ.

“Соломонь чи юу хүсэж байна вэ?” гэхэд, Соломон ингэж хариулав.

“Надад ард түмнээ удирдаж чадах мэргэн ухааныг өгөөч”

Бурхан Соломон хааны хүсэлтийг сонсоод маш их баярлажээ.

Энэ үед хоёр эмэгтэй нэг хүү тэврээд хаан дээр ирэв.

Хоёр эмэгтэй амьд үлдсэн хүүг өөрийнхөө хүү гэж булаацалдан маргалдав.

Соломон хаан бодож байгаад, Бурханы өгсөн мэргэн ухаанаар ийм шийдвэрийг гаргажээ.

“Энэ хүүг хоёр хэсэг хуваа. Тэгээд нэг талыг нь тэр эмэгтэйд нөгөө талыг нь нөгөө эмэгтэйд өг” гэжээ.

Хүмүүс Соломон хааны гаргасан шийдвэрийг сонсоод ихэд гайхжээ.

Гэтэл нэг эмэгтэй нь уйлан хаанд ингэж хэлэв.

“Үгүй ээ, хаантан минь. Хүүг амьд үлдээгээч!

Хүүг хуваасны оронд тэр эмэгтэйд өг дөө” гэжээ.

Харин нөгөө эмэгтэй нь нүдээ хялалзуулан ингэж хэлжээ.



“Тэг, тэг. Хоёр хэсэг хуваагаад өг! Миний ч хүү биш,
тэр эмэгтэйн ч хүү биш байхаар хуваад өг.”

Хэсэг хугацааны дараа, мэргэн ухаант хаан Соломон эцсийн шийдвэрийг гаргажээ.

“Хүүг амьд үлдээгээч гэж гүйж байгаа эмэгтэйд хүүг нь өг. Тэр эмэгтэй бол хүүг төрүүлсэн эх нь мөн!” гэв.

Ингэж Соломон хаан Бурханы өгсөн мэргэн ухаанаар асуудлыг сайн шийдэж чадаж байлаа.

Мөн Соломон хаан, улс орноо мэргэн ухаанаар бас амар тайван дотор үнэхээр сайн удирдан захирч байв.

Түүний тухай яриа газар сайгүй тархжээ.

Тиймээс Соломон хаантай уулзаж аливаа асуудлаа шийдүүлэхээр газар газраас олон хүмүүс түүнийг зорин ирж байлаа.

Холын орон болох Шебагийн хатан хаан хүртэл алт, мөнгө, эрдэнэс, анхилуун үнэртэнг ихээр бэлдэж тэмээнд ачаад Соломон хаантай уулзахаар иржээ. Тэгээд мэргэн ухааныг эрэн хайж Израиль хүртэл хол зам түүлж ирсэн Шебагийн хатан хаан, Соломон хаанаас олон асуулт асуужээ.

Асуулт болгонд нь Соломон огтхон ч эргэлзэлгүйгээр хариулж байв.

Шебагийн хатан хаан Соломон хааны мэргэн ухааныг хараад сэтгэл нь ихэд хөдөлжээ.

Тэгээд түүнд мэргэн ухаан өгсөн Бурханыг магтан алдаршуулаад өөрийнхөө авчирсан бэлгийг Соломон хаанд өгчээ.

Соломон хаан энэ удаад Бурханы ариун өргөөг барих ажлыг эхлүүлжээ.

Ийнхүү Израиль ард түмний хайраар тэрээр долоон жилийг ариун өргөө барих ажилд зориулжээ.

Бурханд зориулж барьсан ариун өргөөний ажлыг дуусгасандаа, Соломон хаан их баяртай байлаа.

Соломон бүх ард түмнийг цуглуулан хамтдаа ариун өргөөг Бурханд өргөжээ.

Тэгээд Соломон хаан Бурханд залбирал өргөсний дараа, Соломон хаан хоёр гараа өндөрт өргөөд ард түмнээ ерөөв.






Гэтэл нэг эмэгтэй нь уйлан хаанд ингэж хэлэв. “Үгүй ээ, хаантан минь. Хүүг амьд үлдээгээч! Хүүг хуваасны оронд тэр эмэгтэйд өг дөө” гэжээ.



8

Мөн Соломон хаан, улс орноо мэргэн ухаанаар бас амар тайван дотор үнэхээр сайн удирдан захирч байв.



Энэ үед хоёр эмэгтэй нэг хүүг тэврээд хаан дээр ирэв.



Соломон хаан бодож байгаад, Бурханы өгсөн мэргэн ухаанаар гайхалтай нэгэн шийдвэрийг гаргажээ.



“Хүүг амьд үлдээгээч гэж гуйж байгаа эмэгтэйд хүүг нь өг. Тэр эмэгтэй бол хүүг төрүүлсэн эх нь мөн!” гэв.



1

Соломон, улс орноо сайн удирдаж чадах мэргэн ухааныг Бурханаас гуйжээ.



“Энэ хүүг хоёр хэсэг хуваа. Тэгээд нэг талыг нь тэр эмэгтэйд нөгөө талыг нь нөгөө эмэгтэйд өг” гэжээ.



Хоёр эмэгтэй амьд үлдсэн хүүг өөрийнхөө хүү гэж булаацалдан маргалдав.

а. Соломон Бурханаас юу гуйсан бэ? Яагаад?

б. Соломон хаан Бурханы ариун өргөөг барихаар болдог. Тэгвэл ариун өргөөг барихад хэдэн жил зарцуулсан бэ?

с. 1Хаад 3:4-15 эшлэлийг уншаад хариулаарай. Бурхан, Соломон хааны гуйсан гүйлтийг сонсоод маш ихэд баярладаг. Үүний дараа Бурхан, Соломон хаанд юу гэж айлдсан бэ?

● Дараах эшлэлийг уншаад, цээжлээрэй. (1Хаад 3:9–10)

Соломон энэ зүйлийг гуйсан нь ЭЗЭНий мэлмийд таашаагдав

